

**Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх
төслийн саналыг хүлээн авах тухай**

Гарчиг: Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн 2023 оны хоёрдугаар улирлын сонгон шалгаруулалтад урьж байна.

Эрүүл мэндийг дэмжих сан нь Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалтын ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлдэг.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 37 дугаар тогтоол, 2021 оны 323 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн 2023 оны хоёрдугаар улирлын төслийн сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох төслийн бичиг баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 17.30 цаг хүртэл хугацаанд Эрүүл мэндийн яаманд хүлээн авна.

Төслийн санал ирүүлэхэд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Төслийн санал ирүүлэх аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь эрүүл мэндийг дэмжих сангийн зорилгод нийцсэн, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар хавсаргасан байх;
- Төсөл хэрэгжүүлэгч нь банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл, өр төлбөргүй болохыг нотлох баримт хавсаргасан байх;
- Тухайн төсөл, арга хэмжээг гүйцэтгэх хүний нөөцтэй байх;

Төслийн зорилго, зорилт нь Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тусгасан зорилтод нийцсэн байна. Төслийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19.3 дахь хэсэгт заасан дараах чиглэлийн дагуу боловсруулна. Үүнд:

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-д заасан чиглэлийн дагуу боловсруулна. Үүнд:
 - Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх;
 - Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
 - Орчны эрүүл мэндийг хамгаалах;
 - Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх;
 - Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи тамхи мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх;
 - Эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах;
 - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх.
2. Төсөлд тавигдах шаардлага:
 1. Төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн нь төслийн зорилго, зорилттой бүрэн нийцсэн;
 2. Хэрэгжих боломжтой, үр дүнгийн урьдчилсан төсөөлөлтэй;
 3. Санхүүгийн тооцоололтой;
 4. Төслийн маягыг зааврын дагуу бүрэн бөглөсөн;

5. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлж байсан туршлагатай бол гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн тухай нотлох баримтыг хавсаргах
3. Хэрэгжүүлэх хугацаа: Төслийг 3 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр тооцож боловсруулна.
4. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй зүйлс: Аливаа татаас, урамшуулал, тусламж болон барилга байгууламж барих, түрээсийн зардал, тавилга, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн худалдан авах зардлыг санхүүжүүлэхгүй.
5. Хавсаргасан маягтын дагуу төслийн саналыг бичсэн байх.
- 1 хувийг хэвлэмэл /цаасан/ байдлаар заасан хугацаанд
 - тухайн байгууллагын албан хүсэлтийн хамт ирүүлнэ.
 - хугацаа хоцорсон тохиолдолд хүлээн авахгүй.
6. Сонгон шалгаруулалтын хариуг мэдэгдэх: Сонгон шалгаруулалтад тэнцээгүй төслийн баримт бичгийг буцаан олгохгүй ба хариу хүргүүлэхгүй болно. Шалгарсан төслийн хэрэгжүүлэгч байгууллагатай холбоо барьж, гэрээ хийнэ.

Лавлах утас: (51) 263925

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр
санхүүжүүлэх төслийн маягт

БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ					
Байгууллагын нэр:					
Байгууллагын хаяг, утас					
Байгууллагын удирдлагын нэр, утас					
Төслийг хариуцах хүний нэр, утас					
Албан тушаал:					
Цахим хаяг:					
Нийт төсөв:					
ТӨСЛИЙН НЭР:					
ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА: /нийт 300 үгэнд багтаан нотолгоо, судалгааны эх сурвалжийг дурьдан бичнэ/					
ЗОРИЛГО, ЗОРИЛТОТ БҮЛЭГ, ҮР ДҮН					
/Төслийн зорилго, зорилт, зорилтот бүлэг, хүлээгдэж байгаа үр дүнгийн талаар нийт 300 үгэнд багтааж бичнэ/					
Зорилго:					
Зорилт:					
Зорилтот бүлэг:					
Үр дүн:					
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ					
Төслийн хүрээнд хийх үйл ажиллагааг дараах хүснэгтэд оруулна уу.					
Д/д	Үйл ажиллагаа	Хийх ажил	Гарах үр дүн	Хугацаа	Нэмэлт тайлбар
ТӨСВИЙН ЗАДАРГАА					
Үйл ажиллагаанд шаардагдах төсвийн задаргааг оруулна уу /Аливаа татаас, урамшуулал, тусламж болон барилга байгууламж барих, түрээсийн зардал, тавилга, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн худалдан авах зардлыг санхүүжүүлэхгүй/					
Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ш	Нэгж үнэ	Нийт үнэ
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА					

Байгууллагын товч танилцуулга /санал болгож байгаа төсөлтэй ижил төстэй чиглэлээр ажиллаж байсан туршлагыг оруулна уу, 300 үгэнд багтаах/					
Төсөл хэрэгжүүлэхэд оролцох хүний нөөцийн товч мэдээлэл					
Д/д	Овог нэр	Төслийн хүрээнд хариуцах ажил	Мэргэжил	Ажилласан жил	Тухайн чиглэлээр ажилласан туршлага (ижил төстэй ажлын тухай мэдээлэл)
ТӨСЛИЙН БАТАЛГААЖИЛТ					
Гарын үсэг, тамга: Нэр: Албан тушаал: Огноо:					